

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2024/69/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл  
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Ахлах аудитор: Ж.Назгүл  
Утас: 88403281 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	11
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж.....	17
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ТТӨХ	Тоног төхөөрөмж

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 <b>БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgii@audit.gov.mn	<b>ЦЭНГЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ж.АЛИМА ТАНАА</b>
2024.02.23 № 322	
танай _____	-ны № _____
<b>Хязгаарлалттай дүгнэлт</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p> <p><b>Дүгнэлтийн үндэслэл</b></p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>1. Сурагчдын үдийн хоолонд зарцуулсан 187,438.5 мянган төгрөгийн хүнсний материалын нярвын тайлан гаргаж орлого, зарлагын тооцоог хийгээгүй, өдөр бүрийн хоолны талон үйлдэж баримтжуулаагүй, тухайн сард үдийн хоолонд хамрагдсан хүүхдийн ирцийн бүртгэлд багш нарын гарын үсэг зуруулсан жагсалтаар зарлага гаргасан.</p> <p>Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.3, 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.5, 20.2.6, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал болон УСНББОУС 1 стандартад нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.</p> <p><b>Асуудлыг онцолсон хэсэг</b></p> <p>Сургуулийн хүүхдийн үдийн хоолны зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна.</p> <p><b>Аудитын гол асуудал</b></p> <p>Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системээс гаргасан цалингийн цэсээр гарт олгох цалингийн дүн болон ажилчдын дансанд шилжүүлсэн дүн зөрүүтэй байгааг</p>	

00402327

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

аудитын явцад цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас баталгаажуулах боломжгүй байсан болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>142,741,670.00</u>	<u>503,178,274.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	84,384,654.00	438,556,800.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	84,384,654.00	438,556,800.00
3121	Төгрөг	84,384,654.00	438,556,800.00
31211	Төрийн сангийн харилцах	84,384,654.00	438,556,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	58,357,016.00	64,621,474.00
354	Хангамжийн материал	58,357,016.00	64,621,474.00
35410	Бичиг хэргийн материал	597,100.00	594,600.00
35420	Аж ахуйн материал	45,887,494.00	47,276,354.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	230,022.00	200,000.00
35450	Барилгын засварын материал	389,000.00	274,000.00
35460	Хүнсний материал	4,232,650.00	9,255,770.00
35470	Бусад хангамжийн материал	7,020,750.00	7,020,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,516,392,324.59</u>	<u>3,260,775,492.12</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,516,392,324.59	3,260,775,492.12
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	1,462,365,324.65	3,205,380,253.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,753,428,706.00	3,431,624,670.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(448,356,483.80)	(543,285,871.74)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,065,200.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,065,200.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	235,148,368.00	215,235,868.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(175,741,540.39)	(72,019,379.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	174,071,317.80	251,189,479.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(102,668,787.06)	(104,425,757.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,010,952.00	14,010,952.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,505,317.90)	(12,827,817.96)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	24,978,110.00	25,878,110.00
393	Биет бус хөрөнгө	54,026,999.94	55,395,238.92
39301	Програм хангамж	550,000.00	1,973,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(165,000.06)	(220,000.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	53,642,000.00	53,642,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,659,133,994.59</u>	<u>3,763,953,766.12</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,659,133,994.59</u>	<u>3,763,953,766.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,659,133,994.59	3,763,953,766.12

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	586,066,331.00	586,066,331.00
51101	Өмч: - төрийн	586,066,331.00	586,066,331.00
512	Хуримтлагдсан үр дүн	(783,119,757.81)	1,321,700,013.72
51210	Өмнөх үеийн үр дүн	(783,119,757.81)	(783,119,757.81)
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,104,819,771.53
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,856,187,421.40	1,856,187,421.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,659,133,994.59</u>	<u>3,763,953,766.12</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,183,549,100.00</b>	<b>5,822,072,003.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>23,215,000.00</b>	<b>1,727,975,203.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	22,565,000.00	1,727,975,203.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	22,565,000.00	6,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,065,000.00	6,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,500,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	1,721,975,203.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	-
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	650,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	650,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,160,334,100.00</b>	<b>4,094,096,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,864,735,600.00	3,898,192,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,837,611,400.00	3,898,192,400.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	27,124,200.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,620,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,620,000.00	-
131106	Төсвийн урамшуулал	-	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	293,978,500.00	195,904,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	293,978,500.00	195,904,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,192,029,091.40</b>	<b>3,717,252,231.47</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,190,351,011.40</b>	<b>3,717,252,231.47</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,996,980,011.40	3,529,813,734.47
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,147,865,277.00	2,571,540,877.00
210101	Үндсэн цалин	1,626,953,065.00	1,694,745,006.00
210102	Нэмэгдэл	475,005,312.00	745,581,235.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	45,906,900.00	131,214,636.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	269,200,800.00	357,791,600.00
210201	Тэтгэврийн даатгал	183,056,300.00	243,298,000.00

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	21,536,200.00	28,623,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,228,800.00	22,898,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,307,400.00	5,724,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	43,072,100.00	57,246,800.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	199,159,000.00	195,934,422.00
210301	Гэрэл, цахилгаан	6,049,674.00	8,850,237.00
210302	Түлш, халаалт	191,109,326.00	185,383,585.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	1,700,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	148,415,546.00	159,155,680.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	148,415,546.00	159,155,680.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,288,000.00	24,376,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,065,000.00	6,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,223,000.00	18,376,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	216,051,388.40	221,014,655.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,468,006.00	72,691,164.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,553,100.00	24,556,456.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	128,030,282.40	123,767,035.47
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	193,371,000.00	187,438,497.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	193,371,000.00	187,438,497.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	193,371,000.00	187,438,497.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,678,080.00</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,678,080.00	-
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	1,678,080.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(8,479,991.40)</b>	<b>2,104,819,771.53</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(8,479,991.40)</b>	<b>2,104,819,771.53</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,136,274,900.00</u>	<u>4,100,096,800.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,065,000.00	6,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,065,000.00	6,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,065,000.00	6,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,065,000.00	6,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,133,209,900.00	4,094,096,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,837,611,400.00	3,898,192,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,837,611,400.00	3,898,192,400.00

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,620,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,620,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	293,978,500.00	195,904,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	293,978,500.00	195,904,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,038,927,246.00</u>	<u>3,599,749,654.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,038,927,246.00	3,599,749,654.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,845,556,246.00	3,412,311,157.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,145,877,300.00	2,572,259,377.00
210101	Үндсэн цалин	1,624,965,088.00	1,706,625,359.00
210102	Нэмэгдэл	475,005,312.00	735,178,718.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	45,906,900.00	130,455,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	269,200,800.00	357,791,600.00
210201	Тэтгэврийн даатгал	183,056,300.00	243,298,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	21,536,200.00	28,623,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,228,800.00	22,898,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,307,400.00	5,724,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	43,072,100.00	57,246,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	199,101,000.00	195,904,400.00
210301	Гэрэл, цахилгаан	6,049,674.00	8,850,237.00
210302	Түлш, халаалт	191,051,326.00	185,353,563.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	1,700,600.00
2105	Нормативт зардал	128,078,046.00	164,178,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс	128,078,046.00	164,178,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	-
210604	Урсгал засвар	1,100,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,774,000.00	24,376,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,065,000.00	6,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,709,000.00	18,376,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,425,100.00	97,800,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,447,600.00	69,224,980.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,977,500.00	28,575,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	193,371,000.00	187,438,497.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	193,371,000.00	187,438,497.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	193,371,000.00	187,438,497.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>97,347,654.00</u>	<u>500,347,146.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,963,000.00	146,175,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,963,000.00	146,175,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,963,000.00	146,175,000.00

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,963,000.00	146,175,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(12,963,000.00)</u>	<u>(146,175,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	84,384,654.00	354,172,146.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		84,384,654.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	84,384,654.00	438,556,800.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	586,066,331.00	1,856,187,421.40	(774,639,765.81)		1,667,613,986.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	586,066,331.00	1,856,187,421.40	(774,639,765.81)	-	1,667,613,986.59
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			(8,479,992.00)		(8,479,992.00)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	586,066,331.00	1,856,187,421.40	(783,119,757.81)	-	1,659,133,994.59
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	586,066,331.00	1,856,187,421.40	(783,119,757.81)	-	1,659,133,994.59
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	586,066,331.00	1,856,187,421.40	(783,119,757.81)	-	1,659,133,994.59
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			2,104,819,771.53		2,104,819,771.53
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	586,066,331.00	1,856,187,421.40	1,321,700,013.72	-	3,763,953,766.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	4,184,482,000.00	3,745,924,654.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	4,184,482,000.00	3,745,924,654.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,957,696,500.00	3,558,486,157.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,946,201,700.00	2,572,259,377.00
210101	Үндсэн цалин	1,994,781,000.00	1,706,625,359.00
210102	Нэмэгдэл	819,965,400.00	735,178,718.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	131,455,300.00	130,455,300.00
210105	Гэрээт ажлын хөлс		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	368,275,300.00	357,791,600.00
210201	Тэтгэврийн даатгал	250,427,300.00	243,298,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	29,462,000.00	28,623,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,569,700.00	22,898,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,892,300.00	5,724,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	58,924,000.00	57,246,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	195,905,000.00	195,904,400.00
210301	Гэрэл, цахилгаан	8,071,000.00	8,850,237.00
210302	Түлш, халаалт	186,134,000.00	185,353,563.00
210303	Цэвэр, бохир ус	1,700,000.00	1,700,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	169,178,800.00	164,178,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс	169,178,800.00	164,178,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	25,650,300.00	24,376,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,000,000.00	6,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,650,300.00	18,376,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	252,485,400.00	243,975,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	223,009,900.00	214,499,980.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,475,500.00	29,475,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	226,785,500.00	187,438,497.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	226,785,500.00	187,438,497.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	226,785,500.00	187,438,497.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	4,184,482,000.00	4,100,096,800.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,898,192,400.00	3,898,192,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,898,192,400.00	3,898,192,400.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	195,905,000.00	195,904,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	195,905,000.00	195,904,400.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	90,384,600.00	6,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000.00	6,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	84,384,600.00	

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		84,384,654.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		438,556,800.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	146.00	146.00
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	94	94
620003	Үйлчлэх ажилтан	49	49
620004	Гэрээт ажилтан	2	2

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Нэмэлт санхүүжилт аваагүй

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага.

Тайлант онд “Сургуульд хамрагдсан суралцагчийг бие даан сурч амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэх” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Монгол Улсын үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Боловсролын ерөнхий газраас сургуулийн 2022 оны санхүүгийн баримтад шалгалт хийж албан шаардлага өгч ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Байгууллагын даргын 2019 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 103 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,104.8 сая төгрөгөөр буюу 126.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	84,384.60	438,556.80	354,172.20
Авлага			0.00
Бараа материал	58,357.00	64,621.50	6,264.50
Үндсэн хөрөнгө	1,516,392.40	3,260,775.40	1,744,383.00
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,659,134.00</b>	<b>3,763,953.70</b>	<b>2,104,819.70</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,659,134.00	3,763,953.70	2,104,819.70
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,659,134.00</b>	<b>3,763,953.70</b>	<b>2,104,819.70</b>

Мөнгөн хөрөнгийн данс 438.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч өмнөх оноос 354.2 сая төгрөгөөр өссөн нь цалингийн зардлаас 384.4 сая төгрөгийн, хоолны зардлын төсвөөс 5.0 сая төгрөгийн, үдийн цайны зардлаас 39.3 сая төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардлын төсвөөс 8.5 сая төгрөгийн, мэдээлэл технологийн зардлын төсвөөс 1.3 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Авлагын данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 64.6 сая төгрөг болж 6.3 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 217.4 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, үйл ажиллагаанд 211.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1.7 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 146.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 178 дугаар тогтоолоор 1,580.9 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 150 хүүхдийн хүчин чадалтай дотуур байр орлого авч, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сургуулийн Б корпус 97.2 сая төгрөгийн их засвар хийсэн байна.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 20.0 сая төгрөгийн сурагчийн ширээ сандал, 18.0 сая төгрөгийн “Дизайн технологийн кабинет”, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 4.4 сая төгрөгийн зөөврийн компьютер болон принтерийг үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 117 тоот хуралдааны тогтоолоор ашиглах боломжгүй болсон байгууллагын данс бүртгэлд байгаа тээврийн хэрэгслийг акталж, дуудлага худалдаагаар худалдан борлуулах шийдвэр гарсны дагуу 5.1 сая төгрөгийн ЗИЛ-130 маркийн автомашиныг данс бүртгэлээс хасаж дуудлага худалдаагаар худалдсан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 156 тоот хуралдааны тогтоолоор үндсэн хөрөнгийн данс бүртгэлд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээ бүрэн нөхсөн 120.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 9.5 сая төгрөгийн тавилга эд хогшлыг акталж дан бүртгэлээс хассан боловч байгууллагын устгалтын комиссын акт үйлдээгүй байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 2.1 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,891.1 сая төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр, зарлагын нийт дүнг 3,891.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж 1,123.3 сая төгрөгөөр буруулж, 2,767.8 сая төгрөгөөр баталсан байна.

Батлагдсан төсвийг 1,130.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3,898.2 сая төгрөгөөр тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны төсвийн хэлбэлзлийн тайлангаар зарцуулах төсөв нь 4,100.1 сая төгрөг байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,904.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 195.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,904.2 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 195.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,745.9 сая төгрөг буюу 89.5 хувьтай байна. Төрийн сангийн харилцах дансанд 438.6 сая төгрөгийн их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	195,905.0	195,904.4	0.6	100.0
2	Байр ашиглалтын үйлчилгээ	7,860.1	7,860.1	-	100.0
3	Сургалт семинар	3,930.1	1,669.0	2,261.1	42.5
4	Эрүүл мэндийг дэмжих	7,860.1	4,476.5	3,383.6	57.0
5	үдийн цай хөтөлбөр	226,785.5	187,438.5	39,347.0	82.7
6	Дотуур байрны үйлчилгээ	291,767.7	276,234.0	15,533.7	94.7
7	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	157,349.5	157,349.5	-	100.0
8	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	17,685.3	15,830.0	1,855.3	89.5
9	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	24,150.0	23,224.8	925.2	96.2
10	Боловсролын стандарт, сургалтын	2,787,965.9	2,433,715.0	354,250.9	87.3
11	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	457,222.8	436,222.8	21,000.0	95.4
12	Сурах бичгийн түрээс	6,000.0	6,000.0	-	100.0
	<b>Нийт дүн</b>	<b>4,184,482.0</b>	<b>3,745,924.6</b>	<b>438,557.4</b>	<b>89.5</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 217.4 сая төгрөгийн бараа материал, 146.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

---

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,190.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 31.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 3,717.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 37.2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан бөгөөд алдаа, зөрчил илрээгүй.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 4,100.0 сая төгрөгийн 12 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 484.1 сая төгрөгийн 28 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 159.5 сая төгрөгийн 41 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр сорил хийсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 458.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 6.2 сая төгрөгийн төлбөрийг нөхөн төлөх 2 төлбөрийн акт, хариуцлага тооцуулах 481.6 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 5.1 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн байна. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд зөрчлийг бүрэн арилгаж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	6,244.1	2	6,244.1	100
Албан шаардлага	3	458,145.2	3	458,145.2	100

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Зөвлөмж	1	5,065.2	1	5,065.2	100
Хариуцлага тооцох	2	481,587.6	2	481,587.6	100
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>951,042.1</b>	<b>8</b>	<b>951,042.1</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайланд нийт 4,201.0 сая төгрөгийн алдаа илэрч залруулга хийгдсэн. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төлөвлөгөөний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 4,184.5 сая төгрөгийн дүнг тайлагнаагүй, нийт зарлага ба цэвэр зээлийн үлдэгдлийн дүнг 9.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийг 6.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

Аудитаар нийт 197.4 сая төгрөгийн зөрчил илэрч 3.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 194.1 сая төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитын дүнгээр 3.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

1.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн А/430 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам”-ыг зөрчиж сургуулийн нийгмийн ажилтан, сургалтын менежер нарт 3,342.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг хууль бус олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/500 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэл”-ийн 4.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

#### 5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр 194.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв. Үүнд:

1.Сургуулийн захирлын 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн Б/14, 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Б/14 дүгээр тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан хавсралтад заасан нэр бүхий албан албан хаагчид 4,143.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг хууль бус олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 2 дахь хэсэг 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн

төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

1.Сурагчдын үдийн хоолонд зарцуулсан 187,438.5 мянган төгрөгийн хүнсний материалын нярвын тайлан гаргаж орлого, зарлагын тооцоог хийгээгүй, өдөр бүрийн хоолны талон үйлдэж баримтжуулаагүй, тухайн сард үдийн хоолонд хамрагдсан хүүхдийн ирцийн бүртгэлд багш нарын гарын үсэг зуруулсан жагсалтаар зарлага гаргаж тооцоо хийсэн байна.

2.Дотуур байрны хүүхдүүдийн хэрэгцээнд авсан 2,527.0 мянган төгрөгийн эмийн үнийг эмийн санчийн хувийн дансанд шилжүүлсэн ба эмийг орлого авч тооцоо хийгээгүй, шууд зарлага гаргаж, шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, “журналд бичих”, 14.3.3 “дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх”, 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй тайлагнасан	1	4,201,000.0			1	4,201,000.0	1	4,201,000.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>4,201,000.0</b>			<b>1</b>	<b>4,201,000.0</b>	<b>1</b>	<b>4,201,000.0</b>				

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Журам зөрчиж нийгмийн ажилтан, сургалтын менежер гарт үр дүнгийн урамшуулал олгосон			1	3342.5								
Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон					1	4,143.6						
Үдийн хоолны материалыг орлого авч, зарцуулалтын тооцоог хийж нярвын тайлан гаргаж тайлагнаагүй, Дотуур байрны хүүхдүүдийн хэрэгцээнд авсан эмийн үнийг эмийн санчийн хувийн дансанд шилжүүлсэн ба эмийг орлого авч тооцоо хийгээгүй, шууд зарлага гаргаж, шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна					1	189 965.5						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>197,451.6</b>	<b>1</b>	<b>3342.5</b>	<b>2</b>	<b>194,109.1</b>						

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
<b>Дүн</b>										
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
<b>Дүн</b>										
<b>Нийт дүн</b>										